# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр Дугаар А/638 Номгон

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, эрх зүй"
уриан дор зохион байгуулагдах өдөрлөгт
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Дэлхийн цагаан таягтны өдөр буюу хараагүйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, эрх зүй" уриан дор өдөрлөг зохион байгуулсугай.

2.Өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн төв" ТББ (Х.Мөнхцэцэг), удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

3.Өдөрлөгийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар батлсугай.

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагаанд зарцуулагдах 1.040.000 /Нэг сая дөчин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

6012104?9

Аймгийн Засаг даргын 2021 оны 10-р сарын
12-ны өдрийн 1/038 захирамжийн. хавсралт

# ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Үйл ажиллагааны зардал | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Хүлээн авалтын хоолны зардал | 60 хүний | 15000 | 900.000 |
| 2 | Хэвлэлийн хулдаас | 1 | 120.000 | 120.000 |
| 3 | Урилга | 10 | 2.000 | 20.000 |
| | Нийт | | | 1.040.000 |

_______o0o______